



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 328

Улаанбаатар хот

Г “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалтыг үндэслэн, эдийн засгийн нөхцөл байдал, үнэт цаасны компаниудын санхүүгийн чадварыг харгалзан ТОГТООХ нь:

Нэг. Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 506 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 8 дугаар хавсралтыг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 8 дугаар хавсралт

“ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН  
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ДООД ХЭМЖЭЭ

Зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ:

- 1) Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа – 30,0 сая төгрөг;
- 2) Үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа – 100,0 сая төгрөг;
- 3) Үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа – 200,0 сая төгрөг;
- 4) Андеррайтерийн үйл ажиллагаа – 1,000,0 сая төгрөг;
- 5) Үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа – 2,000,0 сая төгрөг;
- 6) Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа – 2,000,0 сая төгрөг;
- 7) Үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаа – 2,000,0 сая төгрөг;
- 8) Үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа – 2,000,0 сая төгрөг;
- 9) Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа /кастодиан/-1,000,0 сая төгрөг.”


Хоёр. Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор бүрдүүлсэн байхыг үнэт цаасны зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлэгчдэд үүрэг болгосугай.

000929

Гурав. Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тогтоосон хугацаанд хангаагүй брокер, дилерийн компанийн харилцагчдыг зохих журмын дагуу өөр үнэт цаасны компанид шилжүүлэхийг анхааруулсугай.

Дөрөв. Энэхүү тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүртгэл зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/, Хянан шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА